


1.1 Ордын байршил

Арын нуурын молибдений орд нь Монгол улсын зүүн хэсэгт Сүхбаатар аймгийн хойд хэсэгт оршдог бөгөөд засаг захиргааны харьяалалаар Сүхбаатар суманд ордог ба Чойбалсан-Баруун урт хүрэх гол замаас зүүн урагш 25 км-т, аймгийн төв Баруун-Урт хотоос зүүн хойд зүгт 95 км зайтай оршдог. Чойбалсан хотоос баруун урагш 115км-н зайд оршдог.



Зураг 1. “Арын нуур”, “Арын нуур-1” нэртэй ордуудын байршил

Хүснэгт 1. 9975 Тусгай зөвшөөрөлтэй талбайн булангийн цэгүүдийн солбицлууд

№	Уртгаг	Өргөрөг
1	113° 57' 32.3"	47° 13' 11.81"
2	113° 57' 32.3"	47° 13' 46.8"
3	113° 56' 57.29"	47° 13' 46.8"
4	113° 56' 57.29"	47° 13' 11.81"
5	113° 04' 02.28"	46° 55' 51.76"
6	113° 03' 02.28"	46° 55' 51.76"

Хүснэгт 2. 10889 Тусгай зөвшөөрөлтэй талбайн булангийн цэгүүдийн солбицлууд

№	Уртгаг	Өргөрөг
1	113° 58' 22.29"	47° 14' 11.8"
2	113° 57' 12.29"	47° 14' 11.8"
3	113° 57' 12.29"	47° 13' 46.8"
4	113° 57' 32.3"	47° 13' 46.8"
5	113° 57' 32.3"	47° 13' 11.81"
6	113° 58' 22.29"	47° 13' 11.81"

MV-009975, MV-010889 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайнууд нь Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдахгүй бөгөөд Засгийн газрын 2012 оны 194-р тогтоолоор батлагдсан гол мөрний урсац бүрэлдэх эхийн хил, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хил заагтай тус тус давхцалгүй болно.

1.2 Төслийн талбай

“Молиметал” ХХК -ийн “Арын нуур”, “Арын нуур-1” нэртэй зэс молибдений ордууд нь Монгол улсын зүүн хэсгийн Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт байдаг бөгөөд аймгийн төв Баруун-Урт хотоос 76 км тул зам харилцааны хувьд Арын нуурын ордоос хойшоо 20 орчим километрийн зайтай одоо тавигдаж байгаа хэвтээ тэнхлэгийн автозам дайран өнгөрөх бөгөөд энэ нь ордын районы зам тээврийн нөхцөлийг ихээхэн сайжруулах юм.

Ордын үйлдвэрлэлийн усан хангамжийг ордоос баруун хойш 30 км-т өөрийн компанийн хөрөнгөөр усны эрэл хайгуулын ажил гүйцэтгэн илрүүлж тогтоосон Чихтийн хоолойн усны нөөцийн сангаас бүрэн хангах ба эрчим хүчний хэрэгцээг Чойбалсангийн дулааны цахилгаан станцаас Баруун-Урт хот хоорондох 110 КВТ-н цахилгаан дамжуулах агаарын шугаманд холбож хэрэгцээгээ хангах ба цаашид молибден-зэс баяжуулах үйлдвэрийг барьж байгуулснаар нөөцийг иж бүрэн ашиглах, эдийн засгийн хувьд үр ашигтай байх боломж үүсч байгаа нь Улс, орон нутгийн төсөвт орлого төвлөрүүлэх, мөн орон нутгийн иргэдийг сургаж мэргэшүүлэн ажлын байраар хангах зэрэг эдийн засгийн томоохон үр өгөөжтэй төсөл болох юм.

1.3 Ордын газар зүй

Ордын район нь модгүй тал хээрийн бүст оршдог ба нийтлэг дов толгодтой газрын гадаргатай. Уул толгодын газрын байдал нь өргөн хөндийгөөр хуваагдсан уул нурууд юм. Далайн төвшинөөс (Балтийн тэнгис) дээш 920м-1093.7 метрийн хооронд байдаг ба харьцангуй өндрийн зөрүү ерөнхийдөө 174 метр байна. Районы газар хөдлөлийн хүч 6 балл байна.

1.4 Цаг уур, уур амьсгал

Ордын районы цаг уур нь нийтлэг эх газрын шинжит цаг ууртай. Өвлийн улирал урт, зуны улирал богино бөгөөд агаарын хэмийн зөрүү их байдаг. Цаг уурын гол үзүүлэлт:

Жилийн дундаж агаарын хэм:	0.2°C
Үнэмлэхүй хамгийн өндөр агаарын хэм:	37.8°C
Үнэмлэхүй хамгийн бага агаарын хэм:	-40.1°C
Зуны улирлын дундаж агаарын хэм:	10°C~21°C
Өвлийн улирлын дундаж агаарын хэм:	-10°C~-20°C
Жилийн голлох салхины чиглэл:	Баруун хойноос
Нийт жилийн дундаж салхины хурд:	2-7м/с
Хамгийн хүчтэй салхины хурд:	35м/с

1.5 Ус, хур тунадас

Сүхбаатар аймаг нь ус зүйн мужлалаар ус багатай бүст багтах бөгөөд гадаргуугийн ус ховортой, тогтмол урсгалтай гол мөрөн байхгүй боловч 20 гаруй жижиг нуур, 200-гаад булаг шанд, гол горхи байдаг. Хавиргын булаг, Арын нуур, Арын нуур, Рашаант, Эрээн толгой, Далай булаг, Гашуун, Цавчир, өвдөг, Модонгийн худаг, Цагаан булаг зэрэг рашаан ус олонтой. 2020 оны жилийн эцэст аймгийн хэмжээнд нийт 2955 худаг тоологдсоноос гүн өрмийн 712 ширхэг, богино яндант 171 ширхэг, энгийн уурхайн 1744 худаг байна. 1008.25-1030.0 м-ийн түвшингээс доош газрын ус орших ба бага хэмжээний усжилттай байна.

Жилд орох борооны хэмжээ:	130-280мм (90% нь 5-9 сард ордог)
Цас орох:	10-р сараас дараа жилийн 4-р сар
хүртэл,	дундаж цасан бүрхүүлийн зузаан 3мм

1.6 Нийгэм, эдийн засгийн байдал

Сүхбаатар аймгийн хүн ам цөөтэй, нийт хүн ам жаран мянга хүн ам оршин суудаг байна. Үүнээс Баруун-Урт хотод арван мянга гаруй хүн оршин суудаг. Бэлчээрийн мал аж ахуй голлон эрхлэх бөгөөд төмөр бетон хийцийн үйдвэр, Монгол-Хятадын хамтарсан Төмөртийн- Овооны цайрын уурхай нь үйл ажиллагаагаа тогтвортой явуулж томоохон орд газар байршиж байна. Ордын районы эргэн тойрон нь дов толгод бүхий тал хээр газар ба энэ нь малын бэлчээрийн газар бөгөөд байнгын оршин суугч байхгүй.

Төслийн талбай нь Чойбалсан хотын төмөр замын буудлаас 115 км, Сайншанд хотын төмөр замын буудлаас 400 км, БНХАУ-ын хилийн боомт Дун У Чи /Бичигтийн боомт-оос 318 км -т байрлах ба шороон замаар холбогддог. Монгол улсын бодит эдийн засгийн байдал, Монгол улс ба БНХАУ-ын эдийн засаг, худалдааны харилцааны хамаарлын дагуу бага хэмжээний түүхий эд, материалыг тухайн орон нутгаас хангахаас бусад гол түүхий эд, материалыг бүгдийг нь БНХАУ -аас импортоор авдаг байна.

1.7 Тээвэр

Баруун-Урт хот нь Монгол улсын нийслэл Улаанбаатар хотоос 520 км, хойд зүгт Чойбалсан хотын төмөр замын өртөөнөөс 115 км, баруун зүгт Сайншанд хотын төмөр замын өртөөнөөс 400 км, зүүн тийш БНХАУ-ын хилийн боомт болох Бичигтийн боомт хүртэл 318 км бөгөөд эдгээртэй бүгдтэй нь шороон замаар холбогдоно.

1.8 Харилцаа, холбоо

Харилцаа холбооны хувьд Баруун-Урт хот Мобиком, Скайтел, Юнител зэрэг компаниудын үүрэн холбоог ашигладаг.

1.9 Бүс нутгийн хөгжил

Сүхбаатар аймгийн нэг хүнд ногдох ДНБ-ийн хэмжээ бусад аймгуудын дунджаас дээгүүр. Харин эдийн засгийн эрчмээр (уул уурхайг эс тооцсон ДНБ-ийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хувааж гаргадаг) аймгийн дунджаас доогуур. Аймгийн эдийн засаг уул уурхайгаас хэт хамааралтай, уул уурхайг эс тооцсон ДНБ-ийн хэмжээгээр сул байна. Уул уурхайн салбар аймгийн ДНБ-ийн 40%-ийг бүрдүүлж байгаа ч хөдөлмөр эрхлэлтийн 4%-ийг эзэлдэг. Аймгийн эдийн засгийг хөгжүүлэхэд дараах чиглэлээр хэрэгжүүлэх боломжтой. Үүнд:

Мал аж ахуйг тогтвортой арга зүйгээр хөгжүүлэх :

- Мал аж ахуйн үйл ажиллагааны чанарыг бэхжүүлж, бэлчээрийн талхлалтыг бууруулах, газрын доройтлоос сэргийлэх үүднээс малын тоо толгойг тодорхой хэмжээнд барих
- Өөрийн үйлдвэрлэлээр хэрэгцээгээ хангаж, газар тариалангийн бүтээгдэхүүний эрэлт нийлүүлэлтийн зөрүүг арилгах .

Уул уурхай:

2019 онд 15 уурхай идэвхтэй ажилласан. Тогтвортой үйл ажиллагааг бэхжүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх болон уул уурхайг хөгжүүлж нийгэм, хүний хөгжлийг дэмжих.

Худалдаа, аж үйлдвэр:

Аймгийн аж үйлдвэр Баруун-Урт хотод төвлөрч байна. Сүхбаатар аймаг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний дийлэнхийг бусад аймгаас худалдан авдаг. Мах боловсруулах, ноос угаах үйлдвэрүүдийг байгуулж, 2017 онд байгуулагдсан үйлдвэр технологийн паркийг чадавхжуулах шаардлагатай.

Аялал жуулчлал:

Дарьганга сумыг эс тооцвол Сүхбаатар аймагт жуулчдын сонирхлыг ихээр татах газар байхгүй. БНХАУ-ын хилтэй ойрхон давуу талдаа түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж бололцоо бий.

Тус бүс нутгийг хөгжүүлэхэд тухайн аймгийн давуу тал нь:

Эдийн засаг :

- Мал аж ахуй, уул уурхайгаар дагнасан
 - Ашиг шимтэй малын үүлдэр (ноолуур, махны чиглэл), адуу
 - Баруун-Уртын хүн ам сүүлийн 8 жил өсөлттэй
 - БНХАУ-тай хиллэдэг Бичигт боомт
 - Дарьганга, Эрдэнэцагаан сумын аялал жуулчлалын нөөц
 - Сүхбаатар аймаг хөрш БНХАУ-ын аймгуудтай хилийн худалдааг дэмжих Санамж бичиг
 - Мал аж ахуйн тогтвортой үйл ажиллагаа, боловсруулалтыг хөгжүүлэх
 - УТП-ийн 1-р бүсэд ЖДҮ, 2-р бүсэд агро-аж үйлдвэрийг хөгжүүлэх боломж
 - Сумдад малын яс, арьс шир боловсруулах боломж
 - Баруун-Урт - Сүхбаатар, Бичигт- Хөөт-Нөмрөг чиглэлийн төсөр замаар Сайншанд (Дорноговь), Чойбалсанг (Дорнод) холбосон төмөр зам барих зүйтэй гэж үзсэн байна.
- Хот, суурин:
- Баруун-Урт хотын хүн амын өсөлтийн хувь өндөр (жилд 4%)
 - Баруун-Урт хотын урд хэсэгт амжилттай хэрэгжсэн орон сууцны бүтээн байгуулалт
 - Эрдэнэцагаан сум хоёрдогч жижиг хот (3800 хүн)
 - Баруун-Урт хотын үйлдвэр технологийн парк
 - Төмөр зам барих төлөвлөгөө
 - Бичигт боомтыг хөгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна.

Сүхбаатар аймаг үүл уурхайн салбарт үзүүлэх дэмжлэг, төсөл хөтөлбөр:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлого, түүний “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтийг хангаж буй Хөрөнгө оруулалт, хөгжлийн чуулганы хүрээнд Сүхбаатар аймгийн уул уурхайн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцсон салбар зөвлөгөөнийг зохион байгуулсан ба энэ үеэр Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор “Орон нутгийн хамтын ажиллагаа”-ны хүрээнд 10 гаруй компанитай Хамтран ажиллах гэрээ байгуулжээ. Гэрээнд “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх” зэрэг нийтлэг заалтууд багтдаг байна.

Орон нутгийн хөгжилд гүйцэтгэх үүрэг:

“Молиметал” ХХК нь уг ордыг олборлож, баяжуулснаар худалдан авагч талын шаардлагыг хангасан стандартад нийцсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг экспортод гаргах, байгаль орчин нөхөн сэргээлтийг зохих түвшинд хийж, улс орон нутгийн төсөвт татвар хураамж хэлбэрээр татвар төлж, орон нутагтай хамтран ажиллах гэрээний хүрээнд орон нутгийн хөгжил дэвшилд тодорхой дэмжлэг үзүүлэх юм.

БҮЛЭГ II. ОРДЫН НӨӨЦ, ГЕОЛОГИЙН СУДАЛГАА

Арын нуурын молибденийн орд газарт 1969-1971 онуудад Монгол-Венгерийн хамтарсан геологи-хайгуулын экспедицийнхэн хайгуулын ажил гүйцэтгэж талбайн хэмжээнд 1: 50 000, 1:10 000, 1: 2000 -ны масштабтай геологийн зураглал , Металлометрийн сорьцлолт , геофизикийн цогцолбор ажлуудыг бүрэн хэмжээгээрхийж гүйцэтгэн , улмаар гадаргуугийн болон гүний судалгааг уулын ажил болох суваг, шурф нэвтрэлт, баганат өрөмдлөгийн ажлыг хослуулан хийж нийт ордын хүдрийн хэсэгт доорх ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

1969-1971 оны хооронд хийгдсэн геологи хайгуулын ажлын үр дүнд ордын хэмжээнд үйлдвэрлэлийн балансын нөөц Металлиар 23.0 мян.тн молибден, 7.0 мян.тн зэсийг үйлдвэрлэлийн C1 зэргээр бодон тухайн үеийн ШУТЗөвлөлөөр хэлэлцүүлэх үед тухайн ордын хүдэр баяжуулах технологийн асуудлыг бүрэн шийдвэрлээгүй, мөн ашиглалтын үеийн усан хангамж шийдэгдээгүй байсны улмаас тогтоосон нөөцийг C2 зэргээр хүлээн авсан байна.

Иймд “Арын нуур”, “Арын нуур-1” нэртэй молибден-зэсийн ордын анхны MV-010889, MV-009975 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Резевоирмонголиа” ХХК нь тус орд газарт олборлолт явуулах, уулын баяжуулах үйлдвэр барихаар төслийн ажил хэрэгжүүлэхээр төлөвлөж, ордын нөөцийг Монгол улсад баримталж байгаа ашигт малтмалын ордын нөөцийн ангилалд нийцүүлэхийн тулд молибден-зэсийн нөөцийг үйлдвэрлэлийн В зэрэгт шилжүүлэх геологи хайгуулын нэмэлт ажлууд хийж, нөөцийг баталгаажуулах хяналт шалгалтын ажил явуулах зэрэг үндсэн шаардлагын үүднээс 2007 онд нарийвчилсан хайгуулын ажлыг баганат өрөмдлөгийн аргаар гүйцэтгэсэн байна.

2.1 Ордын районы геологийн тогтоц

“Арын нуур”, “Арын нуур-1” нэртэй ордуудын районы геологийн тогтоц нь үндсэндээ 1969-1970 онд хийгдсэн 1:50 000 -ны геологийн зураглал болон уг ажлаар хийгдсэн геологийн зураг дээр үндэслэгдсэн Дархан хан-Арын нуурын боржингийн тарамцагийн зүүн хойд хэсэгт 350 км² талбайг хамруулсан байдаг юм байна. Баруун өмнөд хэсгээрээ боржингийн биет нь палеозойн депрессээр хязгаарлагдана. Энд хожуу палеозойн хучаас хурдас нь боржингийн биеттэй тектоникийн хил зааг үүсгэн оршдог гэжээ.

Дэлгэр овоогийн район нь их хэмжээтэй боржингийн хэсэгшил маягаар гадаргад байрлах бөгөөд баруун талаасаа Гүн нуурын, баруун хойд ба хойд талаараа цэрдийн хурдсаар дүүргэгдсэн Шавар жаргалантын хотгортой хиллэдэг байна.

Боржингийн биет нь хойд хэсгээрээ хэдэн км урттай хотгор тогтоцтой давхцан оршдог бөгөөд биетийн морфологи болон тектоникийн тогтоц нь жигд биш өмнөд, дунд, хойд гэсэн 3 хэсэгт хуваагддаг. Талбайн ихэнх хэсэг нь боржингийн биетийн хойд хэсэгт хамаардаг. Биетийн энэ хэсэг нь түүний дунд хэсэг болох депрессээс өмнө зүгт 5-10 км - д Алтан-Цагаан уулын орчимд байна. Депресс нь зүүн , зүүн хойноос-баруун, баруун өмнөд зүгт суналтай доод цэрдийн хурдсаар дүүргэгдсэн хотгор юм. Биетийн хойд болон дунд хэсгүүд нь доод цэрдийн хурдас дороос гадарга дээр цухуйж гарсан боржингийн их биш хэмжээтэй гаршуудаар холбогдсон байна. Энэ нь геофизикийн хэмжилтүүдээр тухайлбал боржин нь доод цэрдийн 5-20 м зузаантай тунамал вулкан хурдас доогуур үргэлжилдэг болох нь тогтоогдсон бөгөөд боржингийн биет нь бүхэлдээ агуулагч чулуулгийг зүсэж тэдгээрийг хувиралд оруулжээ. Чулуулгийн насыг 1:50 000 -ны зураглалаар хожуу палеозойд хамааруулсныг баримталж хийв. Хайгуулын талбайн ихэнхи хэсэгт боржин чулуулаг тархсан бөгөөд районы баруун хэсэгт их биш хэмжээтэй доод пермийн эртний төрлийн вулкан чулуулаг, өмнөд болон зүүн өмнөд хэсгээр доод цэрдийн вулканоген-тунамал хурдас тархсан байна гэж үзжээ.

2.2 Давхарга зүй

Доод пермийн вулканоген - тунамал формац / Сизурал- P1/

Энэ формац нь томоохон талбайг хамарсан өргөн тархалттай эртний төрлийн олон янзын найрлагатай хүчиллэг вулканоген чулуулаг голлох ба дагалдах байдлаар дундлаг найрлагатай вулканоген чулуулгууд байдаг. Зузаалгийн нийт зузаан 7 км, үндсэн хэсгийг эксплозив төрлийн игнимбрит, туфф, витрокристалло – литокласт туфф, лавын чулуулгууд бүрдүүлдэг байна. Дагалдах байдлаар тунамал хурдсын хэмхдэсүүд тааралдана гэсэн байна.

Доод цэрдийн вулканоген – тунамал формац / K1

Зураглалын ажлын явцад доод цэрдийн вулканоген – тунамал зузаалгийг доороос дээш 4 горизонтод хуваасан байдаг.

1. Тунамал пирокластик горизонт
2. Эффузив горизонт
3. Вулканоген – тунамал горизонт
4. Тунамал горизонт

Доод цэрдийн хурдас нь петрографи болон стратиграфийн шинжээрээ вулканоген – тунамал горизонттой ижил төстэй байдаг бөгөөд ихэвчлэн талбайн өмнөд болон зүүн өмнөд хэсгээс зөөгдөж ирсэн хурдас байдаг.

Дөрөвдөгчийн хурдас /Плейстоцен-голоцен -Q/

Талбайн хэмжээнд гадаргын хэлбэр, үндсэн чулуулгийн шинж чанар зэргээс шалтгаалан дөрөвдөгчийн хурдас нь нилээд өргөн тархсан байдаг.

Элюви-делювийн хурдас нь гадаргын хотгор хэсэгт валун, ангилагдаагүй ирмэглэсэн чулуулгийн хэмхдэс элс, шаварлаг элс зэргээс тогтсон байдаг. Энэ хурдас нь боржинлог гадарга дээр сайн мөлгөржсөн хэмхдэс ихэвчлэн кварц хээрийн жоншны найрлагатай элс

хайрга зэргээс бүрддэг. Эртний галт уулын чулуулаг нь өнцөглөсөн хэмхдэс материалаар хучигдсан байдаг. Цэрдийн галавын настай чулуулаг нь үндсэндээ өгөршлийн процессын үр дүнд үүссэн хайрга, хайрганцарын хучаас хурдсаар хучигджээ.

Делюви-пролювийн хурдас нь ерөнхийдөө хошуурсан туугдас хэлбэрээр элюви делювийн хэмхдэс материалтай ижил төстэй найрлагатай, хэмхдэс материал нь арай илүү мөлгөржсөн байдалтайгаар тархсан байна.

Алювийн хурдас нь нилээд гүн өргөн хөндийд, хуримтлагдсан элс шаварлаг хурдас, мөн их биш нуурт тогтсон элс нарийн шавар, шаварлаг хурдсууд болон эдгээр дунд байх ангилагдаагүй бүдүүн хэмхдэслэг материал зэргээс тогтжээ. Элювийн хурдаст их бага хэмжээтэй тусгаар нууруудын эрэг даган хуримтлагдсан элсэн манханууд хамаардаг гэжээ.

2.3 Гүний чулуулаг / P–T, J1 /

Дархан хан-Арын нуурын боржингийн биет нь уртрагийн чиглэлд сунаж тогтох бөгөөд 1:200 000 ны зураглалын ажлаар өмнөд, төв, хойд гэсэн 3 хэсэгт хуваагдсан байдаг. Үүнээс манай талбайд хойд хэсэг нь тархсан байдаг байна. Өмнөд болон дунд хэсэгт үндсэндээ том мөхлөгт биотитот боржин /зарим хэсэгтээ аляскит төрөл/ тархсан байдаг. Боржин нь ягаан-саарал өнгийн калийн хээрийн жонш нь бүдэг-саарал өнгөтэй, кварц тунгалаг заримдаа сүүн цагаан, плагиоклаз тоосорхог тогтоцтой байдаг. Заримдаа тэдгээр нь граносиенит төрхтэй болох ба энэ нь том мөхлөгт биотиттой боржинд шилжих хэсгээр тааралддаг гэжээ.

Тухайн үеийн судалгаагаар /Б. Янчки/ ангилснаар боржингийн хойд массивын гол бүрдүүлэгч нь том, дунд мөхлөгт биотиттой боржин бөгөөд өнөөгийн нөхцөлд энэ үний чулуулаг нь насны хувьд дээд перм-триасын галавт хамааруулж байгаа ба мөн дунд болон хойд хэсэгт нилээд залуу юрагийн гүний бүрдэл ялгагддаг гэжээ.

2.4 Судлын чулуулгууд

Судалгааны талбайн хэмжээнд 2 газарт 1018.3 болон 1049.3 м өндөржилтийн тэмдэгтийн эргэн тойронд дунд мөхлөгт биотитод боржин дунд микрогранитын өргөргийн дагуу бага зэрэг сунаж тогтсон жижиг биет илэрсэн байна. Жижиг интрузив нь агаарын зурагт маш сайн тод саарал (тон) өгч тайлагддаг, зөв биш хэлбэртэй байдаг. Чулуулаг нь хүрэн улаан өнгөтэй, зарим хэсэгтээ сулхан порфирлог структуртай, нүдээр саарал өнгийн тосон гялгатай кварц, ягаан хүрэн өнгийн калийн хээрийн жонш сайн ажиглагдсан байна.

Энэ судлын зарим хэсэг нь цахиуржиж цайвар нягт цул болсон байдаг ба өнгө нь тод саарал, ягаан саарал, шар саарал, хүрэн ягаавтар байдаг гэжээ. Жижиг ширхэгтэйгээс гадна цэвэр аплит структуртай мөн аплитын сул шигтгээлэг төрөл байдаг. Шигтгээ байдлаар кварц хээрийн жонш (1-5 мм хэмжээтэй) кварц, хээрийн жонш, ховроор биотит байдаг юм байна. Мөн 1-2 мм хэмжээтэй боржин порфирын судлууд элбэг байдаг. Пегматитын судлууд болон үүрүүд нь 967.6 м өндөртэй уулан дээр 1-5 м зузаантай өргөргийн дагуу суналтайгаар зөвхөн том мөхлөгт боржин дунд тархсан байдаг гэжээ. Судлын зах хэсгээр аплит төрлийн төв хэсгээр цагаан саарал өнгийн кварцын талстууд, бор шаргал өнгийн 1-10 см хүртэл хэмжээтэй ортоклазын талстууд байдаг. Мөн мусковитын хуудаслаг мөхлөгүүд хэдэн см хэмжээтэй биотитын мөхлөгүүд тохиолддог байна. Эрдсийн төрлөөрөө цагаан өнгийн пегматит удлын кварцад үүр маягийн молибденит, гематит, фронделит байдаг. Талбайн дунд хэсэгт 1049.3 м өндөрлөгийн хойд хэсэгт гранофирт кварц порфирын баруун баруун хойноос - зүүн зүүн өмнөд зүгт суналтай, нийт 3 км хүртэл урттай (зарим хэсэгтээ тасралттай) хэдэн метр өргөнтэй шар саарал өнгийн үндсэн хэсэг бүхий судал байдаг. Үндсэн хэсэгт нь 1- 3 мм хэмжээтэй идиоморф гексагональ, бипирамид орон тортой саарал кварц, калийн хээрийн жоншны 1- 4 мм хэмжээтэй ягаавтар мөхлөг байдаг гэжээ.

Ордын өмнө болон баруун өмнө хэсэгт хэд хэдэн газарт андезит порфирын өргөргийн дагуу суналтай хэдэн метр өргөнтэй судал тааралддаг гэжээ. Чулуулаг нь тод хүрэн саарал өнгийн, шигтгээ хэлбэрээр цагаан саарал өнгийн 1 мм хүртэл хэмжээтэй топаз, багаар биотит байна үзжээ. Судлын чулуулгуудын насыг гүний болон галт уулын чулуулагтай үүссэн гарал үүслийн дарааллыг харгалзан нилээд эртнийхээр микрогранит, порфирууд, гранит аплит ба пегматитууд, мөн боржин – диорит порфирит, кварц диоритын судлууд тогтоогдсон бол арай залуугаар дундлаг найрлагатай галт уулын чулуулагт хамаарах андезитын судлууд багтсан байдаг байна.

2.5 Хүдрийн бүсийн дотоод тогтоц, хүдэржилтийн бүсчлэл

Төвийн хүдрийн бүсийн штокверкийн дотоод тогтоц нь боржин чулуулгийн метасоматит хувирал, хувирмал чулуулгийн найрлага зэргээс шалтгаалан штокверкийн төвийн хэсэг нь кварц, кварц–мусковит, мусковит грейзений эрдсийн хам шинжит /грейзений ойр орчимд өндөр температурын кварц–калийн хээрийн жонш, метасоматит/ бүхий 0.04% хүртэл Молибдений агуулга бүхий жишигийн бус хүдэр, 0.04% -аас өндөр агуулгатай Молибдений жишигийн хүдэр гэж ангилсан байна. Штокверкын дотор чанарын хувьд тархалтын нөхцөл дараах байдалтай байна. Гол хагарлаас хойд зүгт ядуу хүдэр зонхилон цооногт илэрдэг бол 11 -р шугамаас өмнө зүгт үйлдвэрлэлийн хүдрээс гадна ядуу хүдэр багагүй хэмжээгээр үүсч өмнө зүг рүү ядуу хүдрийн хэмжээ ихэсч үйлдвэрлэлийн хүдэр аажимаар багасдаг гэжээ. Иймээс хүдрийн биет-1 нь штокверкийн

үйлдвэрлэлийн нөөцийн гол хэсэг нь болдог. Хүдрийн тархалт болон жишигийн агуулгатай хүдрийн хил зааг, нөөцийн тооцоог тусгаар шугамуудаар, агуулгыг цооног бүрээр тооцжээ.

Хамгийн хойд шугам XI шугамын 29, 60-р цооногт молибден 0.042%-0.158% агуулгатай, 33-р цооногт молибденийн агуулга бага зэрэг суларч 0.05 -0.085% болдог. Зэсийн дундаж агуулга дээрх цооногууд 0.068%, 0.036%, 0.018% байдаг. Мөн энэ шугамын цооног D106 -д 0.048-0.153%, D132-д 0.063%, D108 - 0.062-0.15%-н хооронд молибденийн агуулгатай байгаа ба шугамын нийт жишигийн агуулгатай хүдрийн зузаан 623.9 м буюу дундаж хүдэржилтийн итгэлцүүр 0.653, дундажаар энэ шугамд молибден 0.086% , зэс 0.041% агуулгатай байна. Дээрх шугамын хувьд молибденийн жишигийн агуулгатай хүдрийн вариацийн итгэлцүүр 160%, зэсийн хувьд 120% байна. Цооног дахь 0.04% -аас дээш агуулгатай хүдрийн хэсгийн зузаан нь 2 м-ээс 61.5 м -н хооронд байдаг гэж үзжээ.

XII шугамд молибденийн дундаж агуулга 0.085%, цооног D110 -д 0.089%, D112 -д 0.092%, D114-д 0.066%, D116 -д 0.094%, D118 -д 0.112% байна. Зэсийн дундаж агуулга дээрх цооногуудад 0.26%, 0.1%, 0.11%, 0.17%, 0.041% бөгөөд шугамын дундаж агуулга 0.13% байдаг. Шугамын хэмжээнд жишигийн агуулгатай хүдрийн нийт зузаан 449.0 м буюу хүдэржилтийн итгэлцүүр 0.736, цооногууд дахь 0.04%-с дээш агуулгатай хүдрийн хэсгийн зузаан 3 м-ээс 106 м хүртэл тогтоогдсон. /Зураг Энэ шугаманд 11-р шугамтай харьцуулбал молибденийн агуулга үндсэндээ адил, харин зэсийн агуулга эрс өссөн үзүүлэлттэй байжээ. XII шугамын хувьд молибденийн жишгийн агуулгатай хүдрийн вариацийн итгэлцүүр 118%, зэс 108% байна.

XIII шугамд молибденийн дундаж агуулга 0.077%, цооног 5, 56, 27, 31, 1, 57, D120, 72 -д молибденийн дундаж агуулга 0.283%, 0.144%, 0.068%, 0.072%, 0.057%, 0.089%, 0.058%, 0.072% , дээрх цооногууд дахь зэсийн дундаж агуулга 0.137%, 0.024%, 0.033%, 0.046%, 0.06%, 0.059%, 0.026%, 0.016% байна. Тус шугамын молибденийн дундаж агуулга 0.077%, зэсийн дундаж агуулга 0.047% бөгөөд XI, XII шугамаас молибденийн агуулга бага зэрэг буурсан, зэсийн агуулга XII шугамаас буурч XI шугамын үзүүлэлттэй ойролцоо түвшинд ажиглагддаг гэжээ. Шугамын хэмжээнд жишигийн агуулгатай хүдрийн нийт зузаан 339.7 м буюу хүдэржилтийн итгэлцүүр 0.698, цооногууд дахь 0.04%-с дээш агуулгатай хүдрийн хэсгийн зузаан 2.8 м-ээс 60 м хүртэл тогтоогдсон. Вариацийн коэффициент нь Молибденийх 106%, зэс 168% байна.

XIV шугамын цооногууд дахь молибденийн дундаж агуулга D122 -д 0.064%, D124-д 0.077%, D126 -д 0.112%, D128 -д 0.071%, Ск-45 -д 0.19% байгаа ба зэсийн агуулга 0.004 - 0.091% хооронд буюу шугамын дундаж агуулга молибден 0.116%, зэс 0.063% байна. Шугамын хэмжээнд жишигийн агуулгатай хүдрийн нийт зузаан 247.7м буюу хүдэржилтийн итгэлцүүр 0.742, цооногууд дахь 0.04%-с дээш агуулгатай хүдрийн хэсгийн зузаан 3.5 м-ээс 47.5 м хүртэл тогтоогдсон байна. Бусад шугамуудтай харьцуулж үзэхэд молибденийн агуулга дундаж агуулга хамгийн өндөр, зэсийн агуулгын хувьд бага зэрэг өссөн үзүүлэлт ажиглагдах ба нийт жишигийн агуулгатай хүдрийн зузаан буурчээ. Тус шугаманд хийсэн шинжилгээгээр молибденийн вариацийн итгэлцүүр 113%, зэс 99% -тай байна.

XV шугамд өмнөх зэргэлдээ шугамтай харьцуулахад молибденийн дундаж агуулга буурч хойд хэсгийн 3 шугамтай ойролцоо болж 0.08%, шугамын зэсийн дундаж агуулга багасч 0.017%, вариацийн коэффициент нь молибденд 114%, зэсэнд нилээд өндөр 190%, хүдэржилтийн итгэлцүүр 0.652 байна. Энэ шугамд Молибденийн агуулга тусгаар дээжүүдэд 0.01%-0.51% хооронд хэлбэлздэг гэжээ. Си зөвхөн ул мөр төдий байна. Зарим тухайлбал цооног 62-д Мо-0.081, Си-0.005%; цооног 28-д Мо-0.06%, Си-0.015%; цооног 61-д Мо-0.071% , Си-0.014%; цооног D130 -д Мо-0.079%, Си-0.022%, цооног 34-д Мо-

0.089%, Cu-0.023% байна. Жишгийн агуулгатай хүдрийн биетүүд олон хэсэг болон салж нарийнсан жишигийн бус биетүүд ихсэж хоорондуур нь оршдог гэжээ.

ХҮШ шугамд молибдений дундаж агуулга 0.079%, зэс 0.042% вариацийн коэффициент молибденд 117%, зэсийн вариацийн коэффициент харьцангуй өндөр 210%, хүдэржилтийн итгэлцүүр 0.673 байна.

Хүдрийн биет 2-д ХҮШ шугамд Молибдений дундаж агуулга 0.083% , XIX шугамд 0.063% , зэсийн дундаж агуулга энэ хоёр шугамд 0.03%-0.023% хүрдэг гэж үзжээ.

Дээрх үр дүнг нэгтгэн үзвэл хүдрийн бүс дэхь хүдэржилтийн тархалт нь харьцангуй жигд бус болох нь харагдаж байна. Зэсийн тархалт молибдентэй харьцуулбал харьцангуй их жигд бус байгаа нь харагдаж байна. Иймд Арын нуурын орд нь хүдэржилтийн тархалтаараа жигд бус ордод хамаардаг. Вариацийн коэффициент нь үйлдвэрлэлийн хүдэрт Хүдрийн биет-1 -д Мо-121% , Cu-149% байна. Иймд ордын геологийн тогтоцын нийлмэл байдал, хүдэржилтийн дотоод тогтоцыг судалгаагаар хүдэржилтийн итгэлцүүр болон ашигт элементийн тархалтын жигд бусын үзүүлэлт болох вариацийн итгэлцүүрийн тоон үзүүлэлтүүдээр тооцож үзэхэд бидний өмнө баримталж байсан Оросын /хуучин ЗХУ/ аргачлалаар /Ашигт малтмалын ордын нөөц болон хатуу ашигт малтмалын баялгийн ангилал, хэрэглэх зааварчлага "Молибденийн хүдэр" 2007он, Москва хот/ ордыг 4 -н бүлэгт ангилдаг ба манай орд нь хүдэржилтийн итгэлцүүрээр дундаж нь 0.6 -с их буюу 2-р бүлэгт, молибденийн агуулгын тархалтаар вариацийн итгэлцүүр 120 буюу жигд бусаас туйлын жигд бус агуулгатай байгаа нь 3-р бүлэгт багтах ба эндээс дүгнэхэд дээрх ангилалаар 2–3 -р бүлгийн ордод хамаардаг гэж үзжээ.

Хүдрийн эрдсийн найрлага

Төвийн хүдрийн бүсийн эрдсийн найрлагын судалгаа нь 1970–1971 онд Я.Кишийн тайланд, 1967–1968 онд хийгдсэн эрэл үнэлгээний ажлын явц дахь чулуун дээжинд хийсэн петрографи, геохимийн судалгаанд үндэслэгджээ. Хожим 1971 оны К. Строкай, И. Вереш нарын судалгаанд хүдрийн эрдсүүдийг ангилах ангилал хийгдэн доорх байдлаар ангилжээ

Үүнд:

- а. Ислийн хүдрийн эрдсүүд – магнетит, илменит, гематит, касситерит
- б. Ганцаар үүссэн эрдсүүд – вольфрамит
- в. Сульфидийн хүдрийн эрдсүүд ордын хэмжээнд хамгийн их тархалттай.

Исэлдсэн болон холимог бүсүүдэд тархсан хоёрдогч хүдрийн эрдсүүдээр лимонит, гематит, ярозит, повелит, гётит, малахит, азурит зэрэг эрдсүүд тархжээ.

Ислүүд

Шлифэнд магнетит, ильменит, гематит зэрэг эрдсүүд өргөн тархалттай байдаг. Анхдагч эрдсээр титаномагнетит, ильменитүүд үүсч хожмын хоёрдогч хувирлын нөлөөгөөр мартитжсан байдаг. Анхдагч хэлбэр нь изометрлэг хавтанлаг, заримдаа сул дугуй талтай байдаг нь химийн уусалт явагдсаныг илтгэдэг. Магнетитийн бөөн эрдэсжилт бүхий шлифд идиоморф октоэдр талстууд тод ажиглагдана. Тэдгээр нь ихэвчлэн ан цавууддаа пирит, халькопиритын шигтгээ агуулсан байдаг. Үүнээс гадна гематит нь кварцын гидротермаль ялгарлын сүүлчийн үе шатанд үүсдэг. Касситерит: ганц нэг ховор мөхлөгөөр грейзенд түүний үүсэлтэй цуг бүрэлджээ.

Вольфрамит

Хүдрийн бүс дэх ховор эрдсийн тоонд орох бөгөөд зарим шлиф-71 -д тод ялгарсан идиоморф урт сунасан талст байдлаар тааралдах ба гюбнеритийн төрөлд хамаардаг. Гарал үүсэл нь мөн адил грейзентэй холбоотой байдаг гэжээ.

2.6 Сульфидын эрдсүүд

Пирит - Ихэвчлэн идиоморфлог, зарим талууд уусалт явагдсан ялангуяа кварцын судлуудад ихэвчлэн эвдэрч бутарсан мөхлөг хэлбэрээр байдаг. Түүний гарал үүслийн хэд хэдэн генерацийн төрлүүд байх боловч ихэвчлэн халькопирит, халькопирит – кобальтин зэрэг эрдсүүд байна. Пиритийн эхний генераци нь биотит дахь төмрийн хэмжээнээс хамаарч элементийн задралын бага агуулгаас шалтагаалдаг бол сүүлийн генерацид задралын элементийн агуулга их байдаг гэж үзжээ.

Молибденит – Ордын гол хүдрийн эрдэс бөгөөд тархалтаараа пиритын дараа ордог. Ихэнхи хэсэг нь хавтан хэлбэрээр чулуулгийн ан цав хагарал, хоосон зай, цавагт үүсдэг. Зургаан талт талст хэлбэрээр гарал үүслийн хэд хэдэн генераци байжээ. Ритмлэг ассоциаци үүсгэн гялтганууртай–кварцын судланцарын хананд талсжих замаар үүсдэг. Талстын хэмжээ нь хэдэн микроноос хэдэн мм хүртэл байдаг гэжээ.

Халькопирит - Ихэвчлэн сульфидын эрдсүүдтэй цуг ксеноморф хэлбэртэй хоосон орон зайг дүүргэсэн, эсвэл шигтгээ маягаар тохиолджээ. Сфалериттай үргэлж хам ургалт үүсгэдэг, заримдаа түүн дээр ургалт үүсгэсэн байжээ. Сфалеритийн дотоод хэсэгт том хэмжээний халькопирит агуулагдсан. Заримдаа түүнд бүдэг хүдрийн сүүлчийн генераци, мөн молибденитийн том хавтанлаг мөхлөгүүд үүссэн байдаг. Өгөршлийн явцад эрдэс нь халькозин болон ковеллин–халькозины хольц болон түрэгддэг гэжээ. Хэмжээ нь микроны хэдэн хувиас хэдэн мм хүртэл байдаг юм байна.

Сфалерит - Бараг үргэлж бага хэмжээгээр тохиолддог. Түүний ксеноморф мөхлөгүүд нь ургалтын явцад хоёр хуудаслаг структур үүсгэжээ.

Галенит - Маш ховор тохиолддог. Хожуу генерацийн сфалерит, халькопириттэй цуг түүний ксеноморф мөхлөгүүд үүсдэг боловч их хожуу ялгардаг. Хэдэн зуун микроны хэмжээтэй мөхлөг үүсгэжээ.

Бүдэг хүдэр - Маш ховор хүдрийн эрдэс халькопириттэй цуг буюу түүнд шигтгээ маягаар үүсдэг. Сульфидийн эрдсийн сүүлийн генерацид үүсч 20–30 микрон хүртэл хэмжээтэй мөхлөгтэй байсан байна.

Кобальтин - 103 тоот шлиф-д халькопириттэй хам ургалт маягаар түүнд шигтгээгээр үүссэн. Мөхлөгийн хэмжээ 10-20 микрон байжээ.

Халькозин-ковеллин - Халькопиритын бутралын үр дүнд үүсдэг. Ихэвчлэн халькозин үүсч ховроор хоёул үүсдэг. Тэдгээр нь хүчиллэг гидротермаль судлын процессын үр дүн юм. Хэлбэр хэмжээ нь анхдагч халькопиритээс хамаардаг гэжээ .

Киноварь - Шлиф 97 -д 10–20 микрон хэмжээтэй хэдэн тооны мөхлөгүүд тохиолдсон. Мөхлөгийн жижиг байдал нь танихад хүндрэл учруулдаг. Бага температурын гидротермаль процессийн бүтээгдэхүүн юм гэж үзжээ.

2.7 Хоёрдогч хүдрийн эрдсүүд

Ихэвчлэн хүдрийн биетийн дээд хэсгийн исэлдлийн бүс болон завсрын бүст илэрдэг ба тархалтын өөрчлөлт ихтэй. Ганц нэг тохиолдолд тектоник хагаралын бүс дагаж хүдрийн биетийн гүнд үзэгддэг гэжээ. Байнга тохиолддог хоёрдогч эрдэс нь лимонит, гематит, повеллит, ярозит, малахит болон азурит зэрэг ба үүн доторхи төмрийн усан исэл болон гидроксид нь хамгийн түгээмэл хоёрдогч эрдэс юм гэжээ. Хайрслал

байдалтай бүдэг шар өнгөтэй повеллит нь молибденийн хоёрдогч эрдэс гэсэн байна. Шлифт тэдгээр нь хөрслөг шар структуртай, заримдаа арай хүчтэй исэлдсэн нөхцөлд гётитийн фазад шилждэг гэжээ. Исэлдлийн бүс дэх зэсийн эрдсүүд нь исэлдэн ангижирч малахит, азурит зэрэг эрдсүүд сул хөгжсөн цементацийн бүс болон исэлдлийн бүсийн доод хэсэгт үүсдэг гэжээ.

Хүдрийн эрдсүүдийн гарал үүсэл: Зөвхөн хүдрийн аншлифийн судалгаанаас гадна агуулагч чулуулгийн хоёрдогч хувирал болон түүний дараалал чухал ач холбогдолтой. Эдгээрээс үзэхэд хүдрийн эрдэс нь үүсэх явцдаа үндсэн хоёр үе шат дамжсан болохыг тогтоожээ.

Нэг: Харьцангуй сул хүдэржилт бүхий калийн хээрийн жоншжих үе шат юм. Калийн хээрийн жоншжсон чулуулагт молибденитийн шигтгээнүүд үүсжээ. Энэ нь хүдрийн бүсийн зах орчмоор элбэг тохиолддог. Мөн үүнтэй ижил төстэйгээр калийн хээрийн жонш–кварцын бүлэг судлуудад пирит, молибденит зэрэг сульфидийн хүдрүүд үүссэн байдаг. Хүдрийн эрдсүүд нь ихэвчлэн өөр хоорондоо тусгаар байдаг тул тэдгээрийн гарал үүслийн дарааллыг тогтооход хүнд байдаг. Касситерит болон вольфрамитууд нь грейзенжих процесстай нэгэн цаг үед үүссэн боловч ордын хэмжээнд үйлдвэрлэлийн ач холбогдолгүй гэж үзжээ.

Хоёр: Сульфидийн хүдэржилт үүсэх хоёрдох буюу гол шийдвэрлэх үе шат нь грейзенжсэн фаз буюу өндөр температурын гидротермаль хувирал юм. Мөн мезотермаль, эпитеpmаль температурын нөхцөл нь тодорхой үүрэг гүйцэтгэдэг. Сульфидийн эрдсүүд нь төмөр болон титаний усан ислүүдийн дараагаар үүсжээ. Шлифт хийсэн ажиглалтаар магнетит, ильменит нилээд их хэмжээгээр, тэдгээрийн дунд шигтгээ хэлбэрээр пиритийн мөхлөгүүд түүнтэй нэгэн зэрэг талсжих замаар үүссэн байна. Тэгэхээр молибден-зэсийн хүдэржилтийн гол фаз нь пирит үүсэх замаар эхэлж дараа нь молибденит үүссэн байна. Энэ нь молибденит бүхий кварцын судлуудад мөн магнетит тодорхой хэмжээгээр судал маягаар оролцдог гэжээ.

Хүдэржилтийн гарал үүслийн дарааллыг авч үзвэл пирит - халькопирит - молибденит буюу нилээд хожим нь сфалерит үүсжээ. Мөн бүдэг хүдэр, кобальтин нь нилээд хожуу үүсжээ. Хожуу гидротермаль хувирлаар халькозин – ковеллины хольцууд бүрэлджээ.


2.8 Тектоник

Арын нуурын орд орчимын район нь тектоникийн ангиллаар Өмнөт Монголын ороген мужийн Умард Говийн супертеррейны Баруун-Уртын террейны (О.Төмөртоогоо) баруун хойд хэсэгт байршина. Баруун -Уртын террейн нь баруун хойд талаараа Умарт Монголын зөрөг хагарлаар, зүүн - зүүн урд талаараа Буйр нуурын болон Сайхандулааны гүний хагарлуудаар зааглагддаг. Өнөөгийн нөхцөлд районы тектоникийн нөхцөл маш муу судлагдсан. Хагарлын шугамууд нь зөвхөн Төвийн хэсэгт сайн судлагдсан байдаг. Атираат тогтолцоо хаана ч илрээгүй бөгөөд зөвхөн тектоник структур илэрдэг. Боржингийн 2 төрөл нь олон шатлалт тектоникийн хэсэгчилүүдэд хуваагдсан байдаг байна. Тэдгээрийн шилжилт болон холилдсон байдлыг тодорхойлох боломжгүй бөгөөд зөвхөн нэгэн төрлийн чулуулаг дахь тектоникийн хөдөлгөөнийг тухайн хагарлын шугам нь сайн илэрц бүхий судлын биетийг огтолсон тохиолдолд тодорхойлох боломжтой гэжээ.

Бараг өргөргийн дагуу суналтай (зүүн хойш 70° орчим) гол хагарал (главный разлом) нь тусгай зөвшөөрлийн талбай, ордыг хөндлөн зүсэж, баруун хойноос – зүүн урд зүгт суналтай дагуу параллель болон хөндлөн хагарлуудаар хэрчиж тогтсоноор жижиг тектоникийн блокууд болгон хуваасан байна.

Зүүн хойш чиглэлтэй тектоник гол хагарал /F1/ нь ордын хүдрийн талбайг нэвтэлсэн ба хүдрийн биетийг хуваадаг бөгөөд урт нь 25 км-ээс илүү сунаж тогтсон гэжээ.

Гол хагаралтай суналын дагуу давхцаж байгаа хагарлууд нь зүсэгдсэн байдаг ба тэдгээрийн дэргэдүүр хэвтээ чиглэлд шилжүүлсэн хаалттай хагарлуудыг үүсгэдэг байна. Хөндлөн хагаралууд нь нээлттэй, учир нь судлууд нь тэдгээрийн суналын дагуу үргэлжилдэг байна. Талбайн баруун хойд ба зүүн хэсэгт зэрэгцээ байрласан аплитын судлууд нь гол хагаралтай ижил сунал бүхий хагарлуудаар хэрчигдсэн байдаг бөгөөд шилжилтийн хэмжээ /зай/ хэвтээ чиглэлд хэдэн арван метр хүрдэг. Энэ нь гол хагарал болон түүнтэй паралель хагарлуудаас залуу болохыг нотолж байгаан байна.



Зураг 2. Районы геологи-тектоникийн зураг

Хэлбэршүүлэлтийн үндсэн үзүүлэлт	Зураг төслийн зорилт	Зураг төслийн шалгуур үзүүлэлт	Холбогдох хууль эрх зүй
Хаалтын налуу	Хүн, мал, амьтанд аюулгүй байх Үүсмэл нуурын эрэг аюулгүй байх Элэгдэл, эвдрэлд өртөх эрсдэлийг бууруулах	Хэлбэршүүлэлтийн хажуугийн налуу 16.7° Овоолгын тавцан хэсгийн ус зайлуулах налуу 1.15°	MNS5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
Бохирдол	Хүчиллэг урсац үүсэх магадлалыг багасгах	Хүчиллэг урсац үүсэх магадлалын талаар дээжлэлт шинжилгээг хийлгэх	MNS4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт
Хөрс бэлтгэх	Бүс нутгийн ургамал ургах нөхцөлийг бүрдүүлсэн хөрс байх	Урьдчилан нөөцөлсөн шимт хөрс болон органик бодисоор баяжуулсан хөрс	MNS5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
Хучилт хийх хөрс нь	Шимт хөрсний нөөц болон органик сайжруулалт хийж	Байгалийн унаган ургамлыг тарьж ургуулах	MNS5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах
байгалийн унаган ургамал ургах тохиромжтой нөхцөлийг бүрдүүлсэн байх	ашиглах боломжтой хаягдал чулуулаг		MNS5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
Гадаргын усны менежмент	Бохирдсон байж болзошгүй гадаргын усыг ил уурхайн ухашруу нэвтрүүлэхгүй байх	Үерийн хамгаалалтын далан байгуулж, бохирдсон байж болзошгүй гадаргын усны урсцыг хянах	MNS4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт
Гүний усны менежмент	Гүний уст давхарга бохирдохоос сэргийлэх	Хаягдал чулуулгийн овоолгуудын гадаргын усыг зайлуулах	MNS6148-2010 Усны чанар: Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

Овоолгын ирмэг болон гадаргад зураг төслийн дагуу түрэлт, дүүргэлт хийх явцад налуу багатай хэсэгт ус хуримтлагдаж, ирмэгийг давж урсахаас сэргийлэх нь зүйтэй. Зурагт өгөгдсөн ховилуудыг зөв гарган гадаргын усыг чулуун хуягт ус зайлуулах сувгууд руу чиглүүлэх, •Салхи болон гадаргын усны нөлөөгөөр хурц ирмэг, гүн ховил, асгаас зэрэгт элэгдэл, эвдрэл үүсэхээс сэргийлж, өгөгдсөн зургийн дагуу түрж хэлбэршүүлэх,

•Төлөвлөгдсөн хэсгүүдэд чулуун хуягт суваг татах ажлыг зургийн дагуу гүйцэтгэх ба хаягдал чулуулгийн овоолгуудын үндсэн налуугийн өнцгийг алдагдуулахгүй байхаар түрэх, •Сувгийн налууг зөв гаргаснаар хуяг хийх чулууг бага оврын ачаа, тээврийн хэрэгслээр асгах боломж бүрдүүлж, чулуун хуягийг зургийн дагуу байрлуулах, •Овоолгуудын гадаргууд шимт хөрс болон органик бодисоор баяжуулсан хөрсөөр хучиж, ургамал ургах нөхцөлийг бүрдүүлэх.

Хаягдал чулуулгийн овоолгуудын хэлбэршүүлэлтийг уулын ажлын төлөвлөлттэй уялдуулан уурхай ашиглалтын жилүүдэд гүйцэтгэж дуусах бүрэн боломжтой. Энэ нь уурхайн хаалтын үеийн зардлыг үлэмж хэмжээгээр хэмнэх давуу талтай.

Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ Удирдлага зохион байгуулалттай холбоотой зөвлөмж

Төсөл хэрэгжүүлэгч “Молиметал” ХХК нь байгаль орчныг хамгаалах удирдлагын систем чиг баримтлалыг боловсруулан ажиллах нь зүйтэй.

1. Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний байнгын орон тоо гаргаж ажиллуулах.

2. Төсөл хэрэгжих нутгийн байгаль орчны төлөв байдал, төслийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан үзэж одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль эрхзүйн орчинд нийцүүлэн БО-ны бодлогыг тодорхойлох.

3. Туслан гүйцэтгэгч компаниудад БО-ыг хамгаалах үүрэг, хариуцлагыг хүлээлгэх. Гүйцэтгэгчтэй хамтран ажиллах гэрээнд жил бүр уг ажлын гүйцэтгэлийг хэрхэн хангах тухай тусган оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

4. Жил бүр дараах ажлуудыг гүйцэтгэж, холбогдох зөвшөөрлүүдийг сунгуулж, гэрээ байгуулан биелэлтийг хангаж ажиллах.

- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан холбогдох газраар батлуулж, биелэлтийг хангах

- Ус ашиглалтын мэдээ тайланг боловсруулан холбогдох газруудад хүргүүлэх

- Ус ашиглах дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авч, гэрээг байгуулах, гүйцэтгэлийг хангах

- Хаягдал усны дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авч, гэрээг байгуулах,

- Газар ашиглах гэрээг дүгнүүлэх

- Химийн бодис ашиглах зөвшөөрөл авч ажиллах

- Мэргэжлийн байгууллагатай хамтран хог хаягдлыг тээвэрлэн, зайлуулах гэрээг хийж гүйцэтгэлийг хангах.

- Ус, газар, хог хаягдал, агаарын бохирдлын хураамжийг гэрээний дагуу төлөвлөгөөт хугацаанд барагдуулах гэх мэт

5. БО-той холбоотой тодорхой давтамжтай хийгддэг ажлуудыг цаг тухайд нь мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байх.

- 5 жилд нэг удаа газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх

- Жил бүр БОМТ-ыг боловсруулан батлуулж, биелэлтийг хангаж, дүгнүүлэх

- 2 жил тутамд байгаль орчны аудитын ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх.

- Холбогдох зөвшөөрлүүдийг авч, сунгалтыг хийж явах.

ЗӨ 5. Байгууллага нь ажилчдын үүрэгт ажил болон байгууллагын түвшинд байгаль орчны зорилго, зорилтыг тодорхойлох.

- Хүний нөөц, үүрэг хариуцлагыг тодорхойлох.

- БО-ны сургалт семинарыг зохион байгуулж, түүнд хамруулах

– Харилцаа мэдээлэл /янз бүрийн түвшин ба ажил үүргийн хоорондын дотоод харилцаа мэдээлэл, гадны сонирхогч талуудаас ирүүлсэн холбогдох харилцаа мэдээллийг хүлээн авах, баримтжуулах ба түүнд хариу өгөх/

– Баримт бичиг, түүний хяналт

– Үйл ажиллагааны хяналт гэх мэт

ЗӨ 6. Хяналт шалгалт

– Төсөл хэрэгжихийн өмнө хийгдэх байгаль орчны төлөв байдлыг жил бүр хийгдэх БО-ны мониторингийн нэг шалгуур болгох зүйтэй.

– БО-ны суурь нөхцөл нь стандарт шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлох

– БО-ны судалгаа үнэлгээ, хяналттай холбоотой бүртгэлийн хяналт

– Удирдлагын дүн шинжилгээ /Байгууллагын удирдлага нь байгууллагынхаа байгаль орчны удирдлагын тогтолцооны нийцтэй, тохиромжтой, үр ашигтай байдлыг тогтмол хангахын тулд тогтоосон хугацаанд түүнд дүн шинжилгээ хийнэ. Эдгээр дүн шинжилгээнүүд нь байгаль орчны бодлого, зорилго, зорилтуудыг хамруулан байгаль орчны удирдлагын тогтолцоонд өөрчлөлт оруулах хэрэгцээг тодорхойлох, тогтолцоог сайжруулах боломжуудыг үнэлэх асуудлыг авч үзнэ/

Тоосжилттой холбоотой зөвлөмж

Төслийн үйл ажиллагаанаас БО-д үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл тоосжилтын асуудал байна. Тоосжилтыг бууруулах, орчинд нь тарахаас урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах зорилгоор хийгдэх боломжтой арга хэмжээнүүдээс дурдвал:

1. Хашаа хамгаалалт барих: Тоосжилт үүсгэх эх үүсвэрээс салхины зонхилох чиглэлийн дагуу тархах нөхцөлийг бууруулах байдлаар зориулалтын хашаа хамгаалалт барих.

2. Усалгааны систем: Уг уурхай зам усалгааны системийг автомат болгох тал дээр судалгаа хийн туршиж, нэвтрүүлэх.

3. Замын усалгаанд нэмэлт бодис ашиглах: Усалгаа хийхэд дан уснаас гадна нэмэлт бодис ашиглах боломжтой. Нэмэлт бодис ашигласнаар усны зарцуулалт буурч байгаа эсэх, тоосбууруулах үр ашиг, тухайн бодис нь БО-д ямар нэг нөлөөлөл, зардал мөнгө зэргийг харьцуулан судлан, туршиж амжилттай болсон туршлагыг нэвтрүүлэх.

4. Ойн зурвас үүсгэх: Ойн зурвас тодорхой хэмжээний зайд салхины хүчийг өөрчлөн бууруулснаар хөрсний гадаргуу ба ургамлаас ууршин алдагдах чийгийг бууруулна.

5. Тээврийн хэрэгслийн хурдны хяналт хийх. Уурхайн зам дээрх тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах нь тоосжилтыг хянах үр дүнтэй аргуудын нэг юм. Гэхдээ энэ арга нь ажлын бүтээмжид сөргөөр нөлөөлнө.

6. Замын ачааллыг багасгах. Шороон замаар зорчих ачааны автомашинуудын хоорондын зайг тодорхой секундээр хязгаарлан тогтоох.

7. Чанартай зам барих. Чанартай зам барих нь анхдагч зардал өндөр байх хэдий ч замын арчилгаа бага, тоног төхөөрөмжийн засварын зардал буурах, тоосжилтыг үр ашигтайгаар буурах, дугуйн насжилт нэмэгдэх зэрэг урсгал зардлууд буурах боломжтой. Ялангуяа тоос дарагчийн насжилтыг нэмэгдүүлэх, нарийн ширхэгтэй тоос үүсэхийг багасгах нь тоосжилтыг бууруулах гол арга юм.

8. Туршлага судлах: Бусад ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй компаниудаас тоосжилтоос урьдчилан сэргийлэх, бууруулах, амжилттай арилгасан хэрэгжүүлсэн туршлагуудыг судлан, өөрсдийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн туршин үзэх

9. Тоосжилт үүсгэх эх үүсвэрүүдийг битүү болгох. Хэрэв хүдэр дамжуулж буй зөөгүүр болон бутлах тоног төхөөрөмж ил задгай бол түүнийг бүтээх битүү болгох арга

хэмжээг авч хэрэгжүүлэх. Гэхдээ уг арга хэмжээ нь зөөгүүрийн хэвийн ажиллагаа алдагдаж засвар үйлчилгээ хийх явцад саад болох талтай байдаг.

Хөрсөн бүрхэвчтэй холбоотой зөвлөмж

1. Нийт эдэлбэр газрын 10-аас багагүйг хувийг ногоон байгууламж бий болгох
2. Шимт хөрсийг хуулж ургамалжуулан хадгалах.
3. Ил нүхэн жорлон ашиглахгүй байх. Хэрэв бүтээн байгуулалтын үед нүхэн жорлон ашиглах шаардлага гарвал “Нүхэн жорлон, угаадасны нүх техникийн шаардлага – MNS 5924:2015” стандартад нийцүүлэх.
4. ШТМ алдагдсан тохиолдолд, тархахаас сэргийлж зориулалтын шингээгч материал, хэрэгслийг шаардлагатай газарт байршуулах
5. Асгаралтын үед баримтлах журам боловсруулан хэрэгжилтэд хяналт тавих хэрэгтэй

Усан орчинтой холбоотой зөвлөмж

